



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/413

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 8 дугаар тогтоолоор батлагдсан “Төлөөлөгч хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.4.3-т заасны дагуу Төлөөлөгч Д.Нямлхагва БНХАУ-ын Гуанжу хотод ногоон байгууламжийн талаар туршлага судлах сургалтанд хамрагдах зардалд 2,0 /хоёр сая/ төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээний санхүүжилтийг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралт /Хөшөөт хөгжил сан/ 5.3 дахь заалтаас 2,0 /хоёр сая/ төгрөгийг санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөшөөт хөгжил сангийн захирал /Т.Мягмардорж/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/ –д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
06 дугаар сарын 26-ны өдрийн
А/413 дугаар захирамжийн хавсралт

СУРГАЛТАНД ХАМРАГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗАРДЛЫН ТООЦОО

/мянган төгрөгөөр/

Үйл ажиллагаа	Хэмжих нэгж	Нийт үнэ
Зочид буудал	Хоног /5/	592 500
Хөтөлбөрт заасан хоол	Хоног /5/	197 500
Хөтөч	Хоног /5/	118 500
Хөтөлбөрт заагдсан унаа	Хоног /5/	197 500
Хөтөлбөрт заагдсан сургалт	Хоног /5/	262 000
Нислэгийн тийз	2 талдаа	632 000
Нийт үнэ		2 000 000